



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 028

Улаанбаатар хот

Г  
Салбар хороо байгуулах  
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 125 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний дөрөв дэх хөтөлбөр”-ийн хэрэгжүүлэх хоёрдугаар үе шатны ажлын төлөвлөгөөний 2.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, спортын яамны дэргэдэх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, салбар хорооны ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Салбар хорооны үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган, удирдамжийн дагуу ажиллаж, салбарын хөдөлмөрийн, аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг зохицуулж ажиллахыг Дэд сайд, ажлын хэсгийн ахлагч /Д.Атармаа/-д үүрэг болгосугай.

САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА



Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 06 сарын 08. өдрийн  
218 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

**ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ  
БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Салбар хорооны дарга: Эрүүл мэнд, спортын дэд сайд

Орлогч дарга: Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах  
газар (ЭМБХЗГ)-ын Нийгмийн эрүүл мэндийн  
хэлтэс (НЭМХ)-ийн дарга

Нарийн бичиг: ЭМБХЗГ-ын НЭМХ-ийн Химийн бодисын аюулгүй  
байдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт  
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирал

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Орчин,  
хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын секторын эрхлэгч

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн  
Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн захирал

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хөдөлмөрийн  
эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч  
/зөвшилцсөнөөр/

Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн дэд дарга  
/зөвшилцсөнөөр/

Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн  
төлөвлөлтийн хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал  
Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дарга

Хөдлмөрийн эрүүл ахуй, мэргэжлийн өвчин судлалын  
нийгэмлэгийн дэд тэргүүн

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 06. сарын 09. өдрийн  
228.. дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

## ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН САЛБАР ХОРООНЫ АЖИЛЛАХ УДИРДАМЖ

### Үндэслэл

Манай улсад 2013 оны байдлаар 45090 хүн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаагийн 80 гаруй хувь нь эмэгтэйчүүд байна. Эрүүл мэндийн байгууллагын ажилчид нь зүү, хурц үзүүртэй бүтээгдэхүүнд хатгуулах түүнтэй холбоотой халдварт авах, биологийн шингэн, химийн бодис, ионжуулах цацраг, эргономикийн эрсдэлт хүчин зүйлс болон стресст өртөх өндөр эрсдэлтэй нөхцөлд ажилладаг.

2010 онд ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдагсдын 85.9% нь (эмч нарын 80.9%, дунд мэргэжилтний 90.2%, асрагч нарын 81.3%) зүү эсвэл хурц үзүүртэй бүтээгдэхүүний гэмтэлд өртсөн асуумжтай байсан бөгөөд эмнэлгийн нэг мэргэжилтэн жилд дунджаар  $6.13 \pm 3$  удаа ажлын байрандаа энэ төрлийн гэмтэлд өртөж байжээ. Тус судалгаанд хамрагдсан эмнэлгийн ажиллагсдын дундах гепатитийн В, С вирусын халдварт илрэлтийг эрүүл хүн ам дахь тархалттай харьцуулахад өндөр байсан байна.

АШУҮИС-ийн НЭМС-ийн 2014 онд хийсэн эмч нарын ажлын ачааллыг үнэлсэн судалгаагаар эмч нар ажиллавал зохих хугацаанаас дунджаар 24 хувиар, сувилагч, бага эмч, эх баригч нар 25 орчим хувиар илүү цаг ажиллаж байгааг тогтоосон байна.

Ажлын ачаалал болон нөхцөл зэргээс шалтгаалан эмч, эмнэлгийн ажиллагсад ажлын байрны стресст ихээр өртдөг ба энэ нь бие махбодийн болон сэтгэлзүйн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

### Зорилго:

Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангахад удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлэх

### Зорилт/үйл ажиллагаа :

1. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулах талаар эрхзүйн орчин бүрдүүлэх
  - Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
2. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээрх мэдээлэл, сургалт, сурталчилгаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх
  - Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, удирдлагуудыг чадавхижуулах сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг хэлэлцэх, төлөвлөгөө гаргах

3. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг хэлэлцэх, шийдвэр гаргах
  - Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах
  - Эрүүл мэндийн ажилтнуудын ажлын байрны эрсдэлт хүчин зүйлс, өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, хэрэгцээ, шаардлагыг тогтоох, дүгнэлт дээр үндэслэн арга хэмжээ авах
  - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар бусад салбаруудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хамтран ажиллах
4. Салбар зөвлөл нь улиралд нэг удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд хугацаанаас үл хамаарч хуралдана.

**Үр дүн:**

1. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй сайжирна.
2. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах дэд хөтөлбөртэй болно.